



**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**“БАЯНЧАНДМАНЬ ДЭД СТАНЦЫН 0,4 КВ-ЫН ДОТООД ХЭРЭГЦЭЭНИЙ  
ПАНЕЛИЙГ ШИНЭЧЛЭХ” АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

Харьцуулалтын тендерийн дугаар: **ЦДҮС-2019/ХА-19**

УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

### ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **\*Баянчандмань дэд станцын 0,4 кВ-ын дотоод хэрэгцээний панелийг шинэчлэх\*** ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх бараа, ажлын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2019** оны **07** дугаар сарын **25**-ны өдрийн **11:00** цагаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019** оны **07** дугаар сарын **25**-ны өдрийн **11:10** цагт цахим системээр нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд үнийн санал авах баримт бичиг болон бусад мэдээллийг доорхи хаягаар авч болно.

**Улаанбаатар-17060, Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж 26/1 тоот “ЦДҮС” ТӨХК-ийн Улаанбаатар салбарын байр**

**Email:**[ariunbold@transco.mn](mailto:ariunbold@transco.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлт, угсралт суурилуулалтын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл. Үүнд:
      - Сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;
      - Татварын цахим тодорхойлолт;
      - Сүүлийн нэг жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;
      - Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулсан/
      - Компанийн танилцуулга;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) Ажлын тоо хэмжээний дагуу Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм дүрмийн дагуу төсөв зохиох программаар төсөв хийж мэргэшсэн төсөвчнөөр баталгаажуулж ирүүлнэ.
4. Тогтмол үнэ
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан /2018 он/ /аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>- Татварын цахим тодорхойлолт</li> <li>- Сүүлийн нэг жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ,гүйцэтгэлийн акт бичиг баримтын хуулбар/;</li> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулна/</li> <li>- Компанийн танилцуулга.</li> <li>- Санал болгож буй барааны дэлгэрэнгүй танилцуулга, техникийн тодорхойлолт</li> </ul> <p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Техникийн тодорхойлолтод заасан ажлын даалгавар, ажлын тоо хэмжээ, ажлын зураг төслийн дагуу төсөв хийж ирүүлнэ. Төсвийг Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэж эрх бүхийн төсөвчнөөр баталгаажуулсан байна.</li> <li>- Магадлашгүй ажлын зардал, норм нормативын сангийн зардлыг төсөв зохиох зааврын дагуу, татвар хураамжыг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож ирүүлнэ.</li> <li>- Ажил (тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах, туршин шалгах, зүгшрүүлэх, хүлээлгэн өгөх гэх мэт) гүйцэтгэх нарийвчилсан хуваарь гаргаж төлөөлөх эрх бүхий этгээд баталгаажуулж ирүүлнэ.</li> </ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>  Огноо: Тендерийг <b>2019 оны 07</b> дугаар сарын <b>25</b>-ны өдөр  Цаг: <b>11 цаг 00 минут</b>.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Тендер нээх хаяг: <i>Улаанбаатар-17060, Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж 26/1 тоот “ЦДҮС” ТӨХК-ийн Улаанбаатар салбарын байр</i>  Огноо: <b>2019 оны 07</b> дугаар сарын <b>25</b>-ны өдөр <i>нээлт хийнэ.</i>  Цаг: <b>11 цаг 10 минут</b></p>
ТӨӨЗ 7.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>

БАТЛАВ. ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Д.ЖААВАЙ


**БАЯНЧАНДМАНЬ ДЭД СТАНЦЫН ДОТООД ХЭРЭГЦЭЭНИЙ  
ПАНЕЛЬ ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2019.06:14

1. 0,4 кВ-ын иж бүрэн панель буулгах
2. 0,4 кВ-ын тус бүр 20 м урттай кабель демонтаж хийн буулгах
3. 0,4 кВ-ын оролт-2, секц холбогч-1, гаргалга-24 бүхий тоолуур хэмжих хэрэгслээр тоноглогдсон 2.4x1.8x0.8 хэмжээтэй панель суурилуулан хуучин хэрэглэгчдийг холболт хийх
4. Суурилуулах тоолуур нь стандарт хэмжил зүйн газраар баталгаажсан байх
5. 0,4 кВ-ын тус бүр 20 м урттай монгол улсын орчин нөхцөлд таарсан кабель татан үзүүрлэн холболт хийх

Д/Д	Нэршил	тоо	Техникийн үзүүлэлтүүд
1	Оролт-1, 2, секц холбогч	3	0,4 кВ-ын 3 фазын 630 А
2	Гаргалга	4	0,4 кВ-ын 3 фазын 100
3	Гаргалга	12	0,4 кВ-ын 3 фазын 63
4	Гаргалга	8	0,4 кВ-ын 3 фазын 40
5	Оролт-1, 2, секц холбогчийн рубильник	4	0,4 кВ-ын 3 фазын 400
6	Тоолуур хэвийн хүчдэл	2	0,4 кВ-ын 3 фазын тоолуур380
7	Гүйдлийн трансформатор хэвийн гүйдэл/А/	6	400/5
8	Амперметр хэвийн гүйдэл /А/	9	
9	Вольтметр	3	

**110/35/10кВ-ын Баянчандмань дэд станц  
0,4кВ-ын дотоод хэрэгцээний панелиудийн  
техникийн үзүүлэлтүүд**



0,4кВ-н I-р секц	
Гүйдлийн тр- 3Ш	ТК-120 200/5
А37 маркийн автомат 630А	
Тоолуур-1ш	А1805
Амперметр-3ш	400/5
Вольтметр-1ш	
Рубильник-1ш	400А
Автомат	SF4-100А-2ш
	SF4-63 А-6ш
	SF4-40А-4ш
АВВГУ- 3*120+1*35мм2	Кабель 40м

0,4кВ-н II-р секц	
Гүйдлийн тр-3Ш	ТК-120 200/5
А37 маркийн автомат 630А	
Тоолуур-1ш	А1805
Амперметр-3ш	400/5
Вольтметр-1ш	
Рубильник-1ш	400А
Автомат	SF4-100А-2ш
	SF4-63А-6ш
	SF4-40А-4ш
АВВГУ- 3*120+1*35мм2	Кабель 40м

0,4кВ-н СХА	
Амперметр-3ш	400/5
Вольтметр-1ш	
Рубильник-1ш	400А
АВР	630А

Хянасан	АА-ны дэргэ	М.Ууганбаяр
Зурсан	Аш/инженер	Г.Эрдэнэбат
ЦДҮС ТӨХК-н УБС		2017.05.17

**БАРААНЫ ЖАГСААЛТ, БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН БОЛОН УГСРАЛТ СУУРИЛУУЛАЛТЫН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх, угсарч суурилуулах эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлж, угсарч суурилуулах хамгийн эхний хугацаа	Нийлүүлж, угсарч суурилуулах эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1	“Баянчандмань дэд станцын 0,4 кВ-ын дотоод хэрэгцээний панелейг шинэчлэх” ажил	1	ком	ЦДҮС ТӨХК-ийн Улаанбаатар салбар, 110/35/10 кВ-ын “Баянчандмань” дэд станц	14 хоног	21 хоног	



Тав. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлж, угсарч суурилуулахаар санал болгож байна.
2. Нийлүүлж, угсарч суурилуулах бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ, ₮	Нийт дүн, ₮	НӨАТ болон бусад албан татвар, ₮	Бүгд дүн, ₮
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ, ₮							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших  
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт  
2.1. Нийлүүлэгдэж угсарч суурилуулагдах бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх  
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх  
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа  
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах  
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр  
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **(ГТН-д заасан тоо)** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь  
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах  
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах  
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх  
11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
  - 1.1. Барааг нийлүүлсэний дараа Реле хамгаалалт автоматик хэмжилт, туршилтын хэлтсээр шалгуулна. Захиалагчын хяналтыг Улаанбаатар салбарын Ерөнхий инженерээр ахлуулсан техникийн баг гүйцэтгэнэ. Барааний нийлүүлэлт, угсралт суурилуулалтын ажилд бүрэн хяналт тавьж гэрээт ажлыг хүлээн авч акт баримтыг баталгаажуулах үүргийг энэхүү баг хүлээнэ.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
  - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
    - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
    - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
    - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
    - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
    - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
    - 6) Угсарч суурилуулан ашиглалтад оруулсан тухай акт баримт

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
  - 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

Чанарын баталгаат хугацаа 12 сар байна. Баталгаат засварын барьцаа гэрээний үнийн дүнгийн 5% байх бөгөөд тоног төхөөрөмжийг угсарч суурилуулан ашиглалтанд оруулж хүлээлгэн өгсөнөөс хойш 6 сар барина.
4. Төлбөр (ГЕН – 7)
  - 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **95** хувийг барааг нийлүүлж, угсарч суурилуулан хүлээлгэн өгсөн акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
  - 9.1. Алданги оногдуулах хувь: Хоног тутамд гэрээний гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **0.05%** байна.

Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **5%**-иас хэтрэхгүй.

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлж угсарч суурилуулахаар ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлт, угсралт суурилуулалтын ажлыг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж угсарч суурилуулан хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлт, угсралт суурилуулалтын хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*